



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН
ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГА
Ш. ТӨМӨРБААТАР ТАНАА**

2013.10.25 № 01/137 ЧАГ-ГАГ/2013/08

Зөрчил арилгуулах тухай


“Нийслэлд байрлаж байгаа эмнэлгүүдийн эзэмшил газрын ашиглалт, шинээр барих эмнэлгийн хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар Нийслэлийн газрын алба Газрын тухай хууль, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавиагүй, холбогдох газруудын ажлын хариуцлага уялдаа сулаас дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах ХӨСҮТ-ийн эзэмшил газраас ажилчдын 2 орон сууц барих зөвшөөрөгдсөн талбайгаас “Визарьд Гови” ХХК 261 м/кв-аар хэтрүүлэн, 3 дах барилга барьсан,
2. Мөн дээрх ХХК, зөвшөөрөгдсөн талбайг 1279 м/кв-аар, “Жугамт өргөө” ХХК-ний барьсан Шүүхийн ажилчдын орон сууцны хашаа эмнэлгийн эзэмшил газарт 2414 м/кв-аар тус тус нэвтэрч, одоог хүртэл зөвшөөрөлгүй ашиглаж байна.
3. Барилга ХК, 2004 оны газрын төлбөрийг гэрээний хугацаанд төлөөгүй зэргээс үүссэн газрын төлбөр, алданга, торгуулийг хуульд гэрээнд заасны дагуу барагдуулах, зөвшөөрөлгүй газарт баригдсан хашааг чөлөөлүүлэх арга хэмжээ авах.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.. алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлагыг хүргүүлж байна.

Биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн өмчийн харилцааны газрын үнэлгээ, төлбөрийн хэлтсийн дарга Д. Дашцэцэг, газрын кадастрын хэлтсийн дарга Б. Батцэцэг нарт даалгав.

Аудитор



Л.АВИРМЭД

0704-8